

Баян-Өлгий аймаг дахь
Төрийн аудитын газар

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**НӨХӨН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ
ХОЛБОГДОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН
ЗАРДЛЫГ ЖУРАМД ЗААСНЫ ДАГУУ ХУВААРИЛЖ,
ЗАРЦУУЛСАН БАЙНА**

**АУДИТЫН СЭДЭВ: Аймаг, нийслэл, сум, дүүргийн
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн
сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын
төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл**

АУДИТЫН КОД: БӨА-2026/51/ШТА-НА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч,
аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Назгүл
Утас: 99427301 Цахим хаяг: nazguld@audit.gov.mn

Өлгий. 2026 он

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгтийн товъёог	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	4
БҮЛЭГ 1. АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСВИЙГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛСАН БАЙНА.....	7
1.1. Орон нутгийн нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг холбогдох журамд заасны дагуу тооцож хуваарилсан байна	7
1.2. Сонгуулийн хороодод олгох төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна	7
1.3. Орон нутгийн нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотой зарим төрийн захиргааны байгууллагууд төсөв төлөвлөөгүй байна	8
БҮЛЭГ 2. НӨХӨН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ АРВИЛАН ХЭМНЭЛТТЭЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА.....	8
2.1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй зарцуулсан байна	8
2.2. Нөхөн сонгуульд батлагдсан төсвийн гүйцэтгэлийг журамд заасны дагуу тайлагнасан байна	9
2.3. Сонгуулийн зардлын зарцуулалтад журамд заасны дагуу хяналт хэрэгжүүлж ажилласан байна	11
ДҮГНЭЛТ:	12
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:.....	13
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:	14

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийх

Товчилсон үгийн тайлбар

[illegible]

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийх

Хүснэгтийн товъёог

Хүснэгт 1	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2026 оны нөхөн сонгуулийн Баян-Өлгий аймгийн сонгуулийн хорооны төсөв	7
Хүснэгт 2	Сонгуулийн хороодод хуваарилсан төсөв	8
Хүснэгт 3	Баян-Өлгий аймгийн сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэл	9
Хүснэгт 4	Аймаг, сумын сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэл	10
Хүснэгт 5	Аймаг сумын сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэл зардлын төрлөөр	10

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд МУЕА-ын 2026 оны “тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/32 дугаар тушаал, Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийж гүйцэтгэв.
Аудитын зорилт	Сумын ИТХ-ын 2026 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аудитын тайланг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтыг дэвшүүлэн аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: • Сумын ИТХ-ын нөхөн сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх; • Сумын ИТХ-ын нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулсан эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Баян-Өлгий аймгийн аймгийн Сонгуулийн хороо болон Алтанцөгц сумын сонгуулийн хорооны 2026 оны нөхөн сонгуулийн санхүүгийн баримтыг хамруулав.
Аудитын хязгаарлалт	Үгүй
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 3000, 4000, Монгол Улсын төрийн аудитын багц стандарт MNS 6817-2020 “Төрийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ыг ашиглан холбогдох байгууллагаас ирүүлсэн тайлан, цаасан суурьтай нотлох баримт, судалгаа мэдээллийг нягтлан шалгаж, нэгтгэх, харьцуулах, тооцоолох, дүн шинжилгээ хийх зэрэг горим, арга зүйг ашиглав.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийх

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, аудитын менежер Х.Женисбек хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Назгүл аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хамтран гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 2026 оны 07 дугаар сарын 20-ний өдрөөс эхлэн гүйцэтгэж, аудитын тайланг 2026 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн дотор илрүүлэлтийн бүртгэл, судалгааны хамт ҮАГ-т хүргүүлнэ.

Хүндрэл бэрхшээл

Үгүй

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийх

Ерөнхий мэдээлэл

Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын 3 дугаар багийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбоотой Алтанцөгц сумын Сонгуулийн хороог Алтанцөгц сумын ИТХ-ын 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 47 тоот тогтоолоор байгуулсан байна.

Алтанцөгц сумын ИТХ-ын 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн “Алтанцөгц сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуулийн тов тогтоох тухай” 46 тоот тогтоолоор тус сумын ИТХ-ын Улаанхаргана багийн нөхөн сонгуулийг 2026 оны 06 дугаар сарын 21-ний өдөр явуулахаар товлон зарласан байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 121 дүгээр тогтоолоор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуулийг зохион байгуулах аймгийн Сонгуулийн хороог 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Аймаг, нислэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6.¹ -д “энэ хуулийн 10.1.², 10.2.³, 10.3.⁴, 10.4.⁵-т заасан байгууллагуудын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэсний дагуу нөхөн сонгуулийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлсэн байна.

Аймаг, нислэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу Алтанцөгц сумын Сонгуулийн хорооны 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 1/02 тоот тогтоолоор сумын ИТХ-ын нөхөн сонгуулийг зохион байгуулах хэсгийн хороог 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд 1 мандатад 2 нэр дэвшигч өрсөлдсөн ба намын харьяалалаар авч үзвэл Монгол ардын нам, Ардчилсан намаас тус бүр 1 нэр дэвшигч байна.

Нөхөн сонгууль явуулах тойргийн хэмжээнд нэрсийн жагсаалтад санал өгөх сонгогч 466 хүн улсын бүртгэлд бүртгэгдсэнээс 138 хүн буюу 29 хувь нь санал хураалтад оролцсон байна. Сонгуулийн үр дүнгээр Ардчилсан нам 1 суудал авсан байна.

10.6 Орон нутгийн Хурлын ээлжит бус, нөхөн болон дахин сонгууль зохион байгуулахтай холбогдон гарах энэ хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4-т заасан байгууллагуудын зардлыг Монгол Улсын Их Хурал баталж улсын төсвөөс санхүүжүүлнэ.

10.1.Орон нутгийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг Сонгуулийн ерөнхий хорооны төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ:

10.2.Орон нутгийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тухайн жилийн төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ

10.3.Орон нутгийн Хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон доор дурдсан зардлыг цагдаагийн байгууллагын тухайн жилийн төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлнэ:

10.4.Төрийн аудитын дээд байгууллага, онцгой байдлын, тагнуулын, төрийн тусгай хамгаалалтын болон шударга өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын орон нутгийн Хурлын сонгуулийн үйл ажиллагаатай холбогдон гарах улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг тухайн жилийн төсөвт тусгана.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийх

БҮЛЭГ 1. АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСВИЙГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛСАН БАЙНА

1.1. Орон нутгийн нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг холбогдох журамд заасны дагуу тооцож хуваарилсан байна

Сонгуулийн ерөнхий хорооны 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 3/287 дугаар, 05 дугаар сарын 25-ны өдрийн 3/311 дүгээр, 06 дугаар сарын 10-ны өдрийн 3/354 дүгээр албан бичгээр аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуулийн санхүүжилтийн хуваарийг хавсралтаар баталж, тайлбарын хамт ирүүлсэн байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/33 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 2.2.⁶-т заасны дагуу Баян-Өлгий аймагт орон нутгийн нөхөн сонгууль зохион байгуулах зардалд 51,389.3 мянган төгрөг хуваарилсан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2026 оны нөхөн сонгуулийн
Баян-Өлгий аймгийн Сонгуулийн хорооны төсөв

Хүснэгт 1.

(мянган төгрөгөөр)

№	Зардлын нэр	Төсөв
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	77.0
2	Сургалтын зардал	1275.0
3	Бичиг хэрэг	500.0
4	Шуудан холбоо	600.0
5	Унааны зардал	1440.0
6	Санал авах байр бэлтгэх зардал	300.0
7	Сурталчилгааны зардал	700.0
8	Саналын хуудас, ИСР төхөөрөмж авах, хүлээлэгэн өгөх зардал	10392.0
9	МТБ-ийн холбоо, унааны зардал	240.0
10	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал	140.0
11	Томилолтын зардал	4596.0
12	Шуурхай багийн зардал	860.0
13	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	27137.3
14	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, НДШ	3132.0
	дүн	51389.3

Эх сурвалж: СЕХ-ноос хуваарилсан төсвийн судалгаа

1.2. Сонгуулийн хороодод олгох төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна

Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газраас ирүүлсэн албан бичгүүдийн хавсралтаар аймгийн Сонгуулийн хороонд хуваарилсан төсвийг хэрхэн тооцож хуваарилсан талаарх тайлбар, зарцуулах аргачлалыг ирүүлсэн байна.

2.2 . Сонгуулийн ерөнхий хороо нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комисст дараах зардлыг хуваарилна:..

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийх

“Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 2.3.⁷-т заасны дагуу аймгийн сонгуулийн хороо Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газраас ирүүлсэн аргачлал, зөвлөмжийг үндэслэж сумын сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын талаар тайлбар хүргүүлж, сумын сонгуулийн хорооны зарцуулах төсвийг тооцож хуваарилсан байна. Үүнд:

Аймгийн Сонгуулийн хорооны 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 08 тоот албан бичгээр эхний хэсгийн санхүүжилтийн хуваарь, сумын сонгуулийн хорооны төсвийг хүргүүлж 1,380.0 мянган төгрөгийг шилжүүлсэн ба 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 21 тоот албан бичгээр хоёр дахь хэсгийн санхүүжилтийн хуваарь, төсвийг хүргүүлж, хоолны зардалд 1,700.0 мянган төгрөг, урамшууллын зардалд 15,335.0 мянган төгрөгийг хуваарилж шилжүүлсэн байна.

Сонгуулийн хороодод хуваарилсан төсөв		
Хүснэгт 2.		(мянган төгрөгөөр)
№	Сонгуулийн хороо	Төсөв
1	Аймгийн Сонгуулийн хороо	32,974.2
2	Алтанцөгц сумын сонгуулийн хороо	18,415.1
	ДҮН	51,389.3

Эх сурвалж: Аймгийн Сонгуулийн хорооны төсөвт хийсэн судалгаа

Нийт төсвийн 64.2 хувийг аймгийн Сонгуулийн хороонд, 35.8 хувийг Алтанцөгц сумын Сонгуулийн хороонд хуваарилсан байна.

1.3. Орон нутгийн нөхөн сонгууль зохион байгуулахтай холбоотой зарим төрийн захиргааны байгууллагууд төсөв төлөвлөөгүй байна

Орон нутгийн ИТХ-ын нөхөн сонгууль зохион байгуулахад оролцсон аймгийн Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Тагнуулын алба зэрэг байгууллагуудад сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой төсөв батлаагүй байна.

БҮЛЭГ 2. НӨХӨН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ АРВИЛАН ХЭМНЭЛТТЭЙ ЗАРЦУУЛСАН БАЙНА

2.1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй зарцуулсан байна

Сонгуулийн ерөнхий хорооноос Баян-Өлгий аймгийн Сонгуулийн хороонд 51,389.3 сая төгрөгийн санхүүжилтийг батлагдсан төсвийн хуваарийн дагуу шилжүүлсэн байна.

Аймгийн Сонгуулийн хороо батлагдсан төсөв хуваарийн дагуу Алтанцөгц сумын Сонгуулийн хороонд 18,415.1 мянган төгрөгийн санхүүжилт хуваарилж шилжүүлсэн байна.

2.3 . Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо, төв комисс нь Сонгуулийн ерөнхий хорооноос өгсөн тайлбар, аргачлал, байгуулагдсан сум, дүүргийн болон хэсгийн хорооны тоо, түүнд ажиллах гишүүдийн тоо, хол ойрын зай байршлыг харгалзан сум, дүүргийн сонгуулийн хороо, салбар комисст дараах зардлыг хуваарилна: “.....

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийх

Гүйцэтгэлээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуулийн үйл ажиллагаанд 50,327.6 сая төгрөгийг зарцуулж, “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.9.⁸-д заасны дагуу хэмнэсэн 1,061.7 сая төгрөгийг Сонгуулийн ерөнхий хорооны дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Баян-Өлгий аймгийн Сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэл

Хүснэгт 3.

(мянган төгрөгөөр)

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт, хэтрэлт
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	77.0	77.0	0.0
2	Сургалтын зардал	1275.0	1266.3	8.7
3	Бичиг хэрэг	500.0	600.0	-100.0
4	Шуудан холбоо	600.0	455.0	145.0
5	Унааны зардал	1440.0	1440.0	0.0
6	Санал авах байр бэлтгэх зардал	300.0	300.0	0.0
7	Сурталчилгааны зардал	700.0	700.0	0.0
8	Саналын хуудас, ICP төхөөрөмж авах, хүлээлэгэн өгөх зардал	10392.0	10392.0	0.0
9	МТБ-ийн холбоо, унааны зардал	240.0	240.0	0.0
10	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал	140.0	140.0	0.0
11	Томилолтын зардал	4596.0	3588.0	1008.0
12	Шуурхай багийн зардал	860.0	860.0	0.0
13	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	27137.3	27137.3	0.0
14	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, НДШ	3132.0	3132.0	0.0
	ДҮН	51389.3	50327.6	1061.7

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн Сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтад хийсэн судалгаа

“Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.6.⁹-д заасны дагуу төсвийг ангиллын дагуу хэмнэлттэй зарцуулсан байна.

Бичиг хэргийн зардлыг 100.0 мянган төгрөгөөр хэтрүүлж, шуудан холбооны зардлыг 145.0 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 1,008.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэлттэй зарцуулсан байна.

2.2. Нөхөн сонгуульд батлагдсан төсвийн гүйцэтгэлийг журамд заасны дагуу тайлагнасан байна

Аймгийн Сонгуулийн хорооны дансаар зарцуулсан зардлын гүйцэтгэл 31,912.5 сая төгрөг, Алтанцөгц сумын сонгуулийн хорооны дансаар зарцуулсан зардлын гүйцэтгэл 18,415.1 сая төгрөг байна.

Аймгийн Сонгуулийн хорооны төсвөөс сумын Сонгуулийн хороонд хуваарилсан төсвөөс хүрэлцээгүй унааны зардалд 440.0 мянган төгрөг, саналын хуудас, ICP тоног төхөөрөмж хүлээлгэн өгөх унааны зардалд 510.0 мянган төгрөг, томилолтын зардалд 170.0 мянган төгрөг, нийт 1,080.0 мянган төгрөгийг аймгийн Сонгуулийн хорооны данснаас зарцуулсан байна.

3.6 . Сонгуулийн хороод хуваарилсан төсвийг ангиллын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулна.

3.9 . Сонгуулийн санал хураалт явагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор сонгуулийн зардлын үлдэгдлийг Сонгуулийн ерөнхий хорооны дансанд буцаан төвлөрүүлнэ.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийх

Аймаг, сумын сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэл

Хүснэгт 4.

(мянган төгрөгөөр)

№	Сонгуулийн хороо	Төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт, хэтрэлт	Бодит гүйцэтгэл	Бодит хэмнэлт, хэтрэлт
1	Аймгийн сонгуулийн хороо	32974.2	31912.5	1061.7	30832.5	2141.7
2	Алтанцөгц сумын сонгуулийн хороо	18415.1	18415.1	0.0	19,495.10	-1080.0
	ДҮН	51389.3	50327.6	1061.7	50327.6	1061.7

Эх сурвалж: Аймаг, сумын сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтад хийсэн судалгаа

Аймгийн болон Алтанцөгц сумын сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтыг түүвэрлэж зардлын төрлөөр гүйцэтгэлийг шалгахад СЕХ-оос хуваарилсан төсвийн хуваарийн дагуу зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Аймгийн Сонгуулийн хороо нь өмнөх орон нутгийн сонгуулийн төсвийн зарцуулалтын дүнгээр Нийгмийн даатгалын шимтгэлд 205.0 мянган төгрөгийн өглөгтэй байсан байна.

Өмнөх оны НДШ-ийн 205.0 мянган төгрөгийн өглөгийг барагдуулж, тайлант оны нөхөн сонгуулийн зардлын төсвөөс НДШ-д 253.5 сая төгрөгийг ногдуулалтаас илүү шилжүүлж, авлага үүсгэж ажилласан байна.

Аймаг сумын сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэл зардлын төрлөөр

Хүснэгт 5.

(мянган төгрөгөөр)

№	Зардлын нэр	Төсвийн гүйцэтгэл		
		Аймгийн Сонгуулийн хороо	Алтанцөгц сумын Сонгуулийн хороо	Дүн
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	77.0		77.0
2	Сургалтын зардал	1266.3		1266.3
3	Бичиг хэрэг	350.0	250.0	600.0
4	Шуудан холбоо	205.0	250.0	455.0
5	Унааны зардал	600.0	840.0	1440.0
6	Санал авах байр бэлтгэх зардал		300.0	300.0
7	Сурталчилгааны зардал	700.0		700.0
8	Саналын хуудас, ИСР төхөөрөмж авах, хүлээлэгэн өгөх зардал	9882.0	510.0	10392.0
9	МТБ-ийн холбоо, унааны зардал	240.0		240.0
10	Эрчим хүчний эх үүсвэр ашиглах зардал		140.0	140.0
11	Томилолтын зардал	3418.0	170.0	3588.0
12	Шуурхай багийн зардал	860.0		860.0
13	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	12076.3	15061.0	27137.3
14	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, НДШ	1157.9	1974.1	3132.0
	ДҮН	30832.5	19495.1	50327.6

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн Сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын тайлан

Аудитаар сонгуулийн зардлын зарцуулалттай холбоотой алдаа, зөрчил илрээгүй.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийх

2.3. Сонгуулийн зардлын зарцуулалтад журамд заасны дагуу хяналт хэрэгжүүлж ажилласан байна

“Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.10.¹⁰-д заасны дагуу СЕХ нь аймгийн Сонгуулийн хорооны зарцуулалтад, аймгийн Сонгуулийн хороо нь сумын Сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажилласан байна.

3.9 . Сонгуулийн санал хураалт явагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор сонгуулийн зардлын үлдэгдлийг Сонгуулийн ерөнхий хорооны дансанд буцаан төвлөрүүлнэ.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийх

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Орон нутгийн нөхөн сонгуулийн зардлыг холбогдох журамд заасны дагуу төлөвлөж, хуваарилсан байна
2. Нөхөн сонгуулийн төсвийг журмын дагуу хуваарилж, санхүүжүүлсэн байна.
3. Нөхөн сонгуулийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнасан байна
4. Аймаг, сумын Сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтад хяналт тавьж, арга зүйгээр хангаж ажилласан байна.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийх

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:


**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
СОНГУЛИЙН ХОРОО**
83129 Өлгий, Баян-Өлгий аймаг, Өлгий сум,
Утас/Факс: (976) 7042-2595

2026.07.22 № 14.23
танай _____ -ны № _____ - т

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуулийн санхүүгийн баримтад хийсэн аудитын дүгнэлтэд ямар нэгэн санал байхгүй болохыг үүгээр хүргүүлж байна.

ДАРГА  Т.АРШАГҮЛ

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийх

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 07 сарын 23 өдөр

Дугаар

А/20

Өлгий

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, Монгол Улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын хавсралтын 18 дугаар хэсгийн 18.9, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны "Эрх шилжүүлэх тухай" А/175 дугаар тушаалын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд хийсэн нийцлийн аудитын тайланг 1 дүгээр хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлсүгэй.
3. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 10 хоногт багтаан аудитын тайлан, нотлох баримтуудыг архивын нэгж болгон архивд хүлээлгэж өгөхийг аудитын багт даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ЖЕНИСБЕК

802601000044